

**Ц.ДАМДИНСҮРЭНГИЙН ЯРУУ НАЙРАГ ДАХЬ
АМАН ЗОХИОЛЫН УЛАМЖЛАЛ**

Г. Батсуурь*

Монголын орчин үеийн уран зохиолын эхэн үед олон уран бүтээлчид төрөн гарч зохиол бүтээлээ туурвиж байжээ. Тэдгээрийн нэг болох Ц.Дамдинсүрэн нь 1908 онд Дорнод аймгийн Матад сумын нутагт бичээчийн гэр бүлд төржээ. Тэрээр тухайн үеийн ардын хувьсгалын ажилд оролцож явсан ба улмаар уран зохиолын ажилд оролцон Монгол ардын аман зохиол, эртний бичгийн уран зохиолыг сурвалжлан цуглуулах, эмхэтгэн хэвлүүлэх, судлан тодорхойлох зэрэг ажлуудын урд өмнө монголын уран зохиол судлалд байгаагүйгээр идэвхийлэн хийж байсан билээ. Ийнхүү судалгаа шинжилгээний ажлын зэрэгцээгээр өөрөө уран бүтээл бичиж туурвих ажил хийж зохиол бүтээлээ хэвлүүлж байв. Түүний үлдээсэн уран бүтээлийн өв санг судлан тодорхойлох нь зайлшгүй бөгөөд уг ажил нь манай шинэ үеийн уран зохиол хэрхэн үүсэн бий болсон, ийнхүү үүсэж бий болоход ямар ямар хүчин зүйл нөлөөлсөн, анхны уран зохиолын төрөл зүйлүүд ямар байсан зэргийг тодруулан ойлгоход чухал ач холбогдолтой байх нь дамжиггүй юм.

Аливаа цаг үеийн уран зохиол үүсэж хөгжих болон аливаа шинэчлэл хийгдэхэд нийгэм түүхэн цаг үеийн нөлөө болон урд өмнөх урлаг уран зохиолын уламжлал зайлшгүй нөлөөлдөг зүй тогтол байдаг. Манай Монголын шинэ үеийн уран зохиолын үүсэл ч мөнхүү түгээмэл зүй тогтолоос гажаагүй ба нэг талаас ардын хувьсгалын хувьсгалт үзэл санаа нөгөө талаас монгол ардын аман зохиол, эртний уран зохиолын уламжлал гэсэн хоёр үндсэн хүчин зүйлийн нөлөөллийг тусган анхны зохиол бүтээлүүд гарч байсан байна. Тухайн үед буюу 1920, 30-аад оны үед Д.Нацагдорж, Ц.Дамдинсүрэн, Ши.Аюуш, М.Ядамсүрэн, С.Буяннэмэх нарын зэрэг уран бүтээлчид голлох байртай байсан бөгөөд шинэ үеийн уран зохиолыг үндэслэгч хэмээн өдгөө тооцогддог Д.Нацагдорж яруу найргийн мэдрэмж, шинэчлэл, улмаар шинэ үеийн монголын уран зохиолд бичгийн яруу найраг, түүнчлэн шинэ уран сайхны хэл төлөвшин хөгжихөд голлох нөлөө үзүүлсэн гэж үнэлэгддэг бол Ц.Дамдинсүрэн анхны үргэлжилсэн үгийн зохиол болох үлгэр өгүүллэгүүд, анхны уран сайхны тууж, олон арван өгүүллэг, шүлэг найраглалуудаараа манай уран зохиолын түүхнээ үлдсэн.

Ц.Дамдинсүрэнгийн уран бүтээлийг судлаачид янз бүрийн талаас нь дүгнэн бичсэн байдаг. Тодруулбал түүний “*Буурал ижсий минь*” найраглалын тухай “Ц.Дамдинсүрэн найраглалдаа 30-аад оны дунд үеэр монголд болсон нийгмийн түүхэн чухал үзэгдлийг тусгаж монголын өвөрмөц нөхцөлд социализмыг байгуулах үеийн тодорхой шинэсийг харуулсан байна” (7.96, 97) гэж Л.К.Герасимович бичсэн байна.

* МУИС-ийн МХСС-ийн докторант

Мөн шүүмжлэгч Ц.Хасбаатар *“Хувьсгалт шинэ үзэл санаа, шинэ хүний өрнүүн өөдрөг эрмэлзэл бодлыг уран тод тусган харуулсан “Буурал ээж минь” найраглал нь манай яруу найргийн дээжсийн нэг мөн билээ”* (15.144) гэжээ.

Түүнчлэн доктор С.Лувсанвандан *“Монголын орчин үеийн уран зохиолын түүх”-ийн 1-р ботид мөн найраглалыг “Буурал ижий минь найраглалд хувьсгалын ялалтын дараа улс орны амьдралаар тулгарсан ардын боловсролын асуудлыг дэвшүүлж эх үрийн харьцааны уламжлалт сэдвээр захидлын хэлбэрээр уянгын баатраас өгүүлэх аргаар бичжээ. Үүгээр Ц.Дамдинсүрэн монголын яруу найрагт илгээлт-найраглалын хэлбэрийг буй болгосон юм”* (9.166) гэж тэмдэглэсэн буй. Мөн Ц.Дамдинсүрэнгийн *“50 насны ойд зориулсан ерөөл”, “Зөвлөлтийн ард түмэнд зориулсан ерөөл”* найраглалуудын тухай доктор С.Лувсанвандан *“Эл хоёр найраглал уламжлалт ардын ерөөлийн шүлгийн хэлбэрээр бичигджээ. Гагцхүү яруу найрагч агуулгын төдийгүй хэлбэрийн шинэчлэлийг хийжээ.”* (9.167) гэж дурьдсан ба түүний яруу найргийн тухай нь *“Ц.Дамдинсүрэнгийн яруу найраг бол ардын шүлгийн урлагаас эх үндэстэй юм. Түүний шүлэг ардын яруу найргийн уламжлалыг бүтээлчээр хөгжүүлж уран бүтээлийн шинэчлэлийг хийсэн туршлага юм. Ардын аман зохиолын шүлгийн хэмжээ, айзам, бадаг, холбоц, авиа ижилсүүлэх арга, чимэглэл, зүйрлэл зэрэг яруу найргийн зүйн болон уран дүрслэлийн хэрэгсэлд агуулгын төдийгүй хэлбэрийн шинэчлэлийг хийжээ.”* (9.173) гэж дүгнэсэн байна.

Зохиолч, судлаач Д.Цэдэв Ц.Дамдинсүрэнгийн уран бүтээлийн Бүрэн түүврийг эмхэтгэн хэвлүүлсэн бөгөөд түүврийн эхэнд түүний уран бүтээлийн тухай *“Ц.Дамдинсүрэнгийн бүтээлийн өв уламжлал”* сэдэвт өмнөтгөл бичжээ. Д.Цэдэв түүний үргэлжилсэн үгийн зохиолын тухай *“Энэ бол манай зохиолчдын туурвиж байсан үлгэр-өгүүлэгийн домог зүйн болзолт сэтгэлгээнээс шинэ үеийн үргэлжилсэн үгийн реалист өгүүллэг, тууж хүртэл баяжин хөгжсөн явцыг харуулсан жишээ мөн”* (16.33,34) гээд мөн яруу найргийн талаар нь дүгнэлтээ бичсэн ба *“Эдгээрийн дотроос зүйр цэцэн үгээр бүтсэн юм шиг санагдах “Буурал ижий минь” найраглалыг цохон дурьвал зохино.”* (16.35) гэсэн байдаг.

Мөн доктор Д.Галбаатар Ц.Дамдинсүрэнгийн *“Өчүүхэн дөрвөн үлгэр”* зохиолын *“Хаадын байлдаан”* бичил өгүүллэгийн нэгэн захидлын шүлгийн тухай *“...Шүлгийн үгийн байрлалд зориудаар хийсэн энэ өөрчлөлт нь уг захидлын агуулгыг хэлбэрийн тусгай байгуулалтаар илэрхийлснийг харуулна.”* гээд *“...Шүлгийн анхдагч утга бүр эсрэг санаа болон хувирч байгаа нь шүлгийн зохиомжийн тал болох хэлбэртэй шууд холбоотой байна.”* гэж дүгнээд мөн шүлгийг формализмын элементтэй болохыг нь дурьдсан байна. Мөн тэрээр Ц.Дамдинсүрэнгийн *“Толь Гэндэн”* зохиолыг формализмын дүрслэлийн нэгэн арга болох үгээр наадах хэлбэрийн жишээнд дурьдан тодорхойлсон байна. (5.301,313)

Мөн доктор Б.Пүрэв-Очир Ц.Дамдинсүрэнгийн мэндэлсний 100 жилийн ойд зориулан *“Сайн үйлсийг бүтээж салаа замаар явсан эрдэмтэн зохиолч”* нэртэй ном бичиж уг номондоо зохиолч Ц.Дамдинсүрэнгийн уран бүтээлийн хэл найруулга, хэл зүй, утга зүй, нэр зүйн талын баримтуудыг судлан дүгнэсэн байна. Тодруулбал *“Бид энэ өчүүхэн судалбартаа “хүний нэр” хийгээд нүүдлийн соёл иргэниилт монголчуудын “хоч нэр”-ийн учир холбогдлыг цухас төдий сонирхох ташрамд Монгол улсын ууган ардын уран зохиолч Цэндийн Дамдинсүрэн гуайн зохиол бүтээл дэхь баримтат болон уран сайхны “хоч нэр”-ийн (Eng:nick name, Русс:прозвище кличка) онцлог уран сайхны*

найруулгад хэрэглэсэн соёлын содон зарим нэг зүйлийг нь яльгүй боловч тодруулах, нэг хоёр санаа нэмэрлэх зорилго тавьсан юм.” (12,70) гэжээ

Ийнхүү Ц.Дамдинсүрэнгийн уран бүтээлийн тухай өнгөц, хавсарга байдлаар дүгнэн хэлсэн зүйлүүд олон боловч ардын аман зохиол, эртний бичгийн уран зохиол болон өөр бусад уран бүтээлчдийн зохиол бүтээлтэй харьцуулан задлал хийж дүгнэлт өгсөн зүйл хараахан түгээмэл биш байдаг билээ. Тиймээс бид энэ удаад зохиолч Ц.Дамдинсүрэнгийн яруу найргийн бүтээлүүдийг монгол ардын аман зохиолуудтай харьцуулан дүгнэлт өгөхийг зорьсон болно.

Ц.Дамдинсүрэн шүлэг найргийг 1930-аад оноос бичиж эхэлсэн ба 1929 онд “Гологдсон хүүхэн” туужийн оршил шүлэг, “Тайжсийн үг”, “Гэлэн ба гэргий”, 1930-1931 онд “Цэрүү холоос илгээсэн...” гэж эхэлдэг нэргүй шүлэг, 1930 онд Галт тэрэг, Сарьдаг ба совет, Говийн ядуучуудын зовлонг байдлын өгүүлэл, Нударган баяны байдал зэрэг шүлэг ба шүлэглэсэн хэлбэрийн зохиолууд бичжээ. Эдгээр нь ихэвчлэн хуучин нийгмийн гишүүд, шинэ хуучны ялгааг харуулсан өнгө төрхтэй байна. Түүнчлэн тэрээр эх нутаг байгалийн уянгын сэдвээр “Борхын гол” (1932), “Зугаацаар мордсон нь” (1936) найраглал, “Өл буурал хангай” (1941), “Монгол нутаг” (1943), “Хэрлэн” (1945), “Хонд” (1962), “Алс холын нутагт” (1969), “Эх орны дуудлага” (1972), “Нутгаа морөөднө” (1985) зэрэг шүлэг зохиол, нийгмийн шинэ үзэл санаа, найрамдал, нөхөрлөлийн сэдвээр болон шинэ нийгмийн гишүүдийн тухай “Пионерын лагерь” (1932), “Манай цэрэг” (1932), “Хятадын хөдөлмөрчний үг” (1932), “Толь Гэндэн” (1933), “Буурал ижий минь” (1934) найраглал, “Дэлхийн ажилчид дээшээ босч...” гэж эхэлдэг нэргүй шүлэг (1935), “Хоёр настай Ро” (1935), “Пушкин” (1937), “Агуу их нөхрийн тухай дуу” (1941), “Алтан гадас” (1941), “Морьт отряд” (1942), “Бүүвэйн дуу” (1942), “Гацуудлын мэдээ” (1952), “Сүх” (1961), “Дулмаа охиндоо дурсгав” (1961), “Энхрий жүжигчин Матадын Цэвээнжэвт” (1967), “Ильич багш” (1970), “Багануурт бичсэн хэдэн мор” (1981) зэрэг болон “Явж байгаа зам дээр” (1932), “Үдийн нар шиг хонгор минь” (1932), “Янаг” (1934), “Усан дагина” (1934), “Ургамлын сайхан нь” (1934), “Зургийг минь үзвээс ...” гэж эхэлдэг богино шүлэг (1935), “Наалинхай хоёр нүд чинь” (1938), “Ертөнцийн чимэг” (1960), “Янагийн захидал” (1964), “Мөрөөдөл” (1972), “Хонгор минь” (1974) гэх зэрэг хайр дурлалын шүлэг зохиолууд бичжээ.

Мөн тэрээр “Зовлолтийн ард түмэнд зориулсан ерөөл” (1942-1956), “Шинэ жилийн ерөөл” (1944-1956), “Маршал Чойбалсангийн 50 насны ойд зориулсан ерөөл” (1945-1956), “Улаанбаатарт оршин суугч Матад сумын хүмүүсээс өөрийн сумын 50 жилийн ойд зориулсан ерөөл” (1974) зэрэг бүтээл туурвисан байдаг.

Ц.Дамдинсүрэнгийн эхэн үеийн шүлэг зохиолууд нь хуучин нийгмийн гишүүдийг шүүмжилсэн, шинэ үзэл санааг ухуулан сурталчилсан шинжтэй байдаг. Шүлгийн бүтцийн ажиглавал ихэвчлэн толгой сүүл холбосон, мөрийн доторх үгийн тоо тэнцүүлсэн, дөрвөн мөрөөр бадагласан байдаг ба монгол ардын дууны яруу найргийн бүтцийг ерөнхийд нь авч ашигласан байна. Тодруулбал “Гологдсон хүүхэн туужийн оршил” (8.50) шүлэгт монгол ардын дууны эхний бадгийн бүтэц утгыг дараагийн бадагт давтан дүрсэлдэг аргыг ашигласан байна. Жишээлбэл:

Баялаг хэмээн бардамнан

Балмаддаа эрдэж ... гэсэн бол

хоёр дахь бадагт: Түшмэл хэмээн дүрэмдэн

Түгээмэл олныг басаж... гээд

гурав дахь бадагт: Сүнс хэмээн сүрдүүлэн

Сүжигтэн олныг мунхруулж гэх мэтээр давтан дүрсэлжээ. Мөн “Пионерийн лагерь” (8.53) шүлэгт:

Дархан тэнгэрийн амандаа
Далан хүүхэд нөхөрлөөд...
Бөгд уулын сугандаа
Бүжигнан дэвхцэн баясалцаад... гэж бичсэн бол

“Үдийн нар шиг хонгор минь” (8.61) шүлэгт:

Үдийн нар шиг хонгор минь
Үзэгдэж гийгүүлээд ирэвч... гээд дараагийн бадгийн эхэнд:
Хар тунгалаг нүд чинь
Хажууд ойрхон тормолзовч... гэж

“Наалинхай хоёр нүд чинь” (8.98) шүлэгт:

Наалинхай хоёр нүд чинь
Намрын ус шиг мэлтэжнэнэ... гээд хоёр дахь бадгийн эхэнд:
Шингэн цагаан царай чинь
Шинэ цаснаас ялгаваргүй... гэсэн бол

“Цэцэг” (8.232) шүлэгт:

Хаврын цэцэг ургаж гэнэ
Халуун наранд дурлаж гэнэ... гээд дараагийн бадгийн эхэнд:
Бадам цэцэг ургаж гэнэ
Бараан үүлэнд дурлаж гэнэ гэх мэтээр ахиулан давтаж дүрсэлсэн

байна.

Ийнхүү эхний бадгийн бүтэц утгыг ахиулан давтсан дүрслэлийг “Хятадын хөдөлмөрчний үг”, “Буурал ээж минь” найраглал, “Хоёр настай Ро”, “Зугаацаар мордсон нь” найраглал, “Пушкин”, “Танкч”, “Монгол нутаг”, “Нам”, “Хонгор минь” зэрэг олон шүлэг зохиолуудаас нь харж болохоор байна. Эдгээр нь монгол ардын ихэнх дуунд байдаг давталтаас уламжлал авсан байгаа юм. Тухайлбал монгол ардын дуу “Мандах нар”, “Арван тавны сар”, “Гандий мод”, “Ган төмөр”, “Алсын газрын зэрэглээ”, “Чи минь байдаг” зэрэг олон дуунаас эхний бадгийг дараагийн бадагт ахиулан давтсан дүрслэлүүдийг үзэж болно. Жишээлбэл:

“Алсын газрын зэрэглээ” (10.175) дуунд:

Алсын газрын зэрэглээ нь хө
Адуу шиг, мал шиг торолзоно... гээд дараагийн бадагт:
Холын газрын зэрэглээ нь хө
Хонь шиг хурга шиг торолзоно... гэсэн байдаг бол “Чи минь

байдаг” (10.170) дуунд: Барайгаад байдаг баян хайрхан

Багираад байдаг хонин сүрэг... гээд дараагийн бадагт:
Сүүмэлзээд байдаг Сүвээтийн толгод
Сүрэглээд байдаг хонин сүрэг... гэх мэтээр дүрсэлсэн

байдаг.

Тэрээр ийнхүү ардын дууны бадгийн давталтаас уламжлал аваад зогсохгүй тодорхой ардын дуунаас уламжлал авсан “Явж байгаа зам дээр”, “Бүүвэйн дуу” зэрэг бүтээл туурвижээ. “Явж байгаа зам дээр” (8.61) шүлэгт:

Явж байгаа зам дээр
Ягаан өнгийн цэцэг байна
Яасан сайхан өнгөтэй

Ямар сайхан цэцэг вэ?
Хажууд яваа найз минь
Хархан нүдтэй бүсгүй байна
Хараад байхад аятайхан
Хаашаа янзын бүсгүй вэ?...

гэж шүлэглэсэн байдаг бол монгол ардын “Замбага ягаан цэцэг” дуунд:

Зам дээр ургадаггүй
Замбага ягаан цэцэг нь
Зам дээр яагаад ургаа вэ?
Замбуулин хорвоод
Хань болохгүй хүний үр
Надад яагаад дасаа вэ?...

гэсэн байдагтай жишиж үзвэл утгын хувьд өөрчлөн шинэчилсэн хэдий ч уран асуултыг хэрэглэсэн, хайр сэтгэлийн тухай өгүүлсэн зэргээрээ уламжлал авчээ гэж үзэх үндэстэй байна. “Бүүвэйн дуу” шүлгийн хувьд бол монгол уламжлалт бүүвэйн дууны өнгө аяс, утга агуулгатай тохирч байна.

Монгол ардын дуунаас гадна Ц.Дамдинсүрэнгийн бүтээлүүдэд монгол ардын зүйр цэцэн үгсээс ашигласан уламжлал авч баяжуулан шинэчилсэн зүйлүүд нэлээд байна. Түүний 1931 онд бичсэн “Говийн ядуучуудын зовлонт байдлын өгүүлэл” (8.51,52) зохиолд:

Өндөр уулыг давахад бэрх
Өргөн говийг гатлахад бэрх...

гэсэн байдаг бол түүний “Толь Гэндэн” (8.62-70) зохиолд нь:

Олныг хэсэж
Олгой тэжээж
Гүрнийг хэсэж
Гүзээ тэжээж... гэх буюу
...Хөнжлөөрөө дүүрэн
Шар хүүхэдтэй болж
Хөгнөөрөө дүүрэн
Цагаан хургатай болж
Ам самандаа

Амар сайхан жаргажээ гэх мэтээр дүрсэлсэн буй.

Түүнчлэн зарим судлаачдын зүйр цэцэн үгээс бүтсэн юм шиг гэж онцлон дурьдсан байдаг “Буурал ээж минь” (8.71-80) найраглалд:

...Энэ бие өсөж
Эрийн цээнд хүрлээ
Эр бие чангарч
Хүний зэрэг боллоо...
...Эегүй нөхөр яг
Эрдэмгүй хүн таг...
...Аавын бийд хүнтэй танилцах
Агтны бийд газар үзэх
Эд хураахаар эрдэм сурах...
...Эхийн санаа үрд

Үрийн санаа ууланд... гэх мэтийн 10 гаруй зүйр цэцэн үгийг зохиолд шигтгэн оруулсан байна. Мөн тэрээр “Халтар ишиг” (8.201-203) зохиолдоо:

...Эвлэвэл бүтнэ

Ховловол гутна...

гэдэг зүйр цэцэн үгийг оруулжээ. Энэ мэтээр түүний ихэнх бүтээлүүдээс зүйр цэцэн үг буюу зүйр цэцэн үгийн бүтэц, утгыг дуурайлган зохиосон олон жишээ баримтыг үзэж болохоор байгаа юм.

Монгол ардын аман зохиолын уламжлалтай түүний бас нэгэн сонирхолтой бүтээлүүд нь ерөөл нэртэй зохиолууд болно. Үүнд “Зөвлөлтийн ард түмэнд зориулсан ерөөл” (1942-1956), “Шинэ жилийн ерөөл” (1944-1956), “Маршал Чойбалсангийн 50 насны ойд зориулсан ерөөл” (1945-1956), “Улаанбаатарт оршин суугч Матад сумын хүмүүсээс өөрийн сумын 50 жилийн ойд зориулсан ерөөл” (1974) зэрэг бүтээлүүд хамаарна. Монгол ардын ерөөл нь тухайн зүйлийн ирээдүйн сайн сайхныг зөгнөн ерөөсөн эхлэл хэсэг, үндсэн хэсэг, төгсгөл хэсэгтэй байдаг ба янз бүрийн зан үйлтэй холбоотой байдаг. Энэ тухай нь монголч эрдэмтэн Б.Я.Владимирцов “Ерөөл нь ихэнхдээ янз бүрийн зан үйл болон аж байдлын бусад үзэгдэлтэй маш нягт холбоотой байдаг” (2.6,7) гэсэн байдаг. Мөн судлаач эрдэмтэн Ш.Гаадамба, Х.Сампилдэндэв нар “Магтаалд аливаа юмс үзэгдлийг тоочин магтах хандлага түгээмэл байдаг бол ерөөлд ихэвчлэн цаг хугацааны дарааллаар солигдох үйл хөдлөлт дүрслэлийг хийсэн байдаг” (3.107) гээд ерөөлийн эхлэл хэсэг, үндсэн хэсэг, төгсгөл хэсгүүдийн тухай нь тодорхойлжээ. Монгол ардын ерөөлүүд нь дээрх судлаачдын дурсан онцлог шинжүүдтэй байдаг бол Ц.Дамдинсүрэнгийн зохиосон ерөөлүүд нь ч мөн дээрх онцлогуудыг хадгалж байна. Тодруулбал ямар нэгэн тэмдэглэлт ойд зориулсан эхлэл, үндсэн, төгсгөл хэсгүүдтэй бөгөөд ер нь л монгол ардын ерөөлийн бүтэц хэмнэлээр бичигджээ. “Зөвлөлтийн ард түмэнд зориулсан ерөөл” (8.114-125) бүтээлийн эхлэл хэсэгт монгол нутагт өвс ус, өл хоол дутвал баруун хойноос аврал ирнэ гэсэн санааг гаргаад үндсэн хэсэгт монголчуудыг зовж зүдэрч байхад нь зөвлөлтийн ард түмэн хэрхэн тусалж аварсныг өгүүлээд төгсгөл хэсэгт нь зөвлөлтийн ард түмэнд сайн сайхныг ерөөсөн байдаг бол “Шинэ жилийн ерөөл” (8.175-178) зохиолд монголын ард түмний амьдрал ирж буй шинэ жилд өөрсдийн хөдөлмөр зүтгэл, зөвлөлтийн ард түмний тусалцаагаар сайн сайхан болж:

....Элгээрээ энх мэнд

Төрлөөрөө түвшин энх

Сайхан жаргаж явахын

Сайн ерөөлийг саатуулан айлтгая!

гэж өгүүлсэн байна. “Маршал Чойбалсангийн тавин насны ойд зориулсан ерөөл” (8.181-194) –д:

Төр улсын өндөрлөг болсон

Түмэн ардын нөхөр болсон

Төгс зоригт Чойбалсан таныхаа

Төрсөн өдрийн баяр болсонд...

гэж ерөөх эхлэлээ гаргаад үндсэн хэсэгт улс орондоо хэрхэн хувьсгал хийж өөрчилсөн болохыг дэлгэрэнгүй өгүүлээд төгсгөлд нь:

Удирдагч нөхөр Чойбалсангийн

Уул бие лагийн нь

Улам улам батжиж...

...Урт насалж
Удаан жаргаж явахын
Сайн ерөөлийг
Саатуулан айлтгая!

гэж мөн монгол ардын ерөөлийн байдлаар төгсгөсөн байдаг. “Улаанбаатарт оршин суугч Матад сумын хүмүүсээс өөрийн сумын 50 жилийн ойд зориулсан ерөөл” (1974) бүтээл нь ч мөн ижил юм.

Зохиолч Ц.Дамдинсүрэн монгол ардын магтаалаас уламжлал авсан бүтээлүүд ч нэлээдийг туурвисан болох нь харагддаг. Тэдгээрээс “Зугаацаар мордсон нь” (1936), “Монгол нутаг” (1943) зэрэг бүтээлүүд нь сонирхолтой юм. Монгол ардын магтаал нь ерөөлтэй төстэй боловч үндсэн шинжээрээ өөр юм. Энэ тухай Ш.Гаадамба, Х.Сампилдэндэв нар “...Тухайлбал, хоёуланд нь тухайн зүйлийг бахдан сайшаах санаа байдаг боловч ерөөлд түүний ирээдүйг зөгнөн бичдэг бол магтаалд одоогийн байгаа сайн сайхныг магтан батжуулах утгыг илэрхийлсэн байдаг” (3.121) гэжээ. Тэгвэл Ц.Дамдинсүрэнгийн “Зугаацаар мордсон нь” зохиолд Үүл, Уул, Ус, Ургамал гэсэн хэсгүүдээр монгол орны үзэсгэлэнт байгалийг магтан шүлэглэсэн байдаг. Энд ямар нэгэн зүйлийн ирээдүйг зөгнөсөн зүйлгүй байна. Уг зохиолын дүрслэл нь байгалийн үзэгдлийг зураглан буулгасан бөгөөд монгол уламжлалт дүрслэх урлагийн хээ угалз, эвэр угалз болон монгол хавтгай зураг шиг байдаг онцлогтой юм. Монгол ардын магтаалд магтаж байгаа зүйлээ хүртэн харж буйгаа “...Баруун талаар нь тойроод харахад, Зүүн талаас нь харвал, Үзүүрийг нь бариад гарахад, Хөвчид нь гараад ирэхэд...” гэх мэтээр өгүүлдэг бол “Зугаацаар мордсон нь” (8.88) зохиолд эхлэл хэсэг болгон:

...Зугаа цэнгэл хийж
Хөдөө гадаа явъя гэж
Хүлэг сайн морио
Барьж аваад уналаа
Хүүхэн хонгор түүнийгээ
Дагуулж аваад гарлаа...

гэж тойрон явж магтаж байгаа мэтээр шүлэглэжээ. Мөн түүнчлэн уг найраглалд:

Элгэн их хаданд нь
Бүргэд шувуу хальсан
Эрэг жалга бүгдэд нь
Араатан гөрөөс шивээлсэн... (8.91) гэх буюу

...Жижиг ногоо үргэлжилж
Ногоон хилэн дэвсгэр шиг
Жимс амттан бөнжигнөж

Эрдэнэт сайхан унжлага шиг... (8.94) гэх мэтээр зураглан өгүүлсэн нь

“Алтайн магтаал”-ын: (13.217)

...Даваагаар нь даваад ирэхэд
Тахь буганы гүйдэлтэй
Далдын баялаг уурхайтай

Дайрга чулуу багатай... гэх зэргийн дүрслэлүүдээс уламжлалтай болох нь мэдэгдэж байна. Түүний “Монгол нутаг” (8.133) шүлгийн эхний мөрүүдэд:

Цагаан цасан малгайтай
Ногоон модон хүрэмтэй

Хөх усан хормойтой

Баян хангай уул минь... гэсэн бол “*Алтайн магтаал*” нь: (13.219)

Мөнх цасан эхтэй

Мөлгөр чулуун оргилтой

Өргөн түмэн, хүдэр ондөр

Баян хан Алтай нутаг минь гэв гэнэ... гэж эхэлдэг. Эдгээрийг харьцуулж үзвэл “*Монгол нутаг*” шүлэг нь мөн л магтаалын уламжлалтай нь болох нь тодорхой байна. Гэтэл энд нэгэн сонирхолтой баримт олдсон нь академич Ц.Дамдинсүрэнгийн өөрийнх нь олж “**Монгол уран зохиол судлалын зарим асуудал**” өгүүлэлдээ мэдээлсэн ноён хутагт Д.Равжаагийн “*Галбын уулын магтаал*” дууны 2-р бадагт:

Элдэг цасан тэргүүнтэй

Элдэв цэцгийн цамцтай

Эрээн зүлгэн хормойтой

Эрдэм төгс орон юм... (.....Олон монгол хэл бичгийн эрдэмтний анхдугаар их хурал 2-р боть. УБ. 2009.хэвлүүлсэн ака. Ш.Бира. 55х.) гэсэн магтаал шүлэг юм. Эдгээрийг харьцуулж үзвэл уламжлал авсан байдал тодорхой ажиглагдана. Эндээс бид Ц.Дамдинсүрэн аман зохиол төдийгүй бичгийн зохиолоос ч уламжлал авч байсан болохыг мэдэж болохоор байна.

Дээрх баримтуудаас ажиглавал Ц.Дамдинсүрэнгийн яруу найргийн бүтээлүүд нь монгол ардын дуу, зүйр цэцэн үг, ерөөл, магтаал болон ер нь монгол ардын аман зохиолын өргөн уламжлалтай болох нь харагдаж байна. Тэрээр ардын аман зохиолын уламжлалыг тухайн үеийн нийгмийн шинэчлэл өөрчлөлт, хувьсгалт шинэ үзэл санаагаар баяжуулан шинэчилсэн бүтээлүүд туурвижээ. Ц.Дамдинсүрэнгийн шинэчлэл нь зөвхөн хувьсгалт шинэ үзэл санаагаар хязгаарлагдахгүй ба тэрээр “*Янаг*” (1934), “*Ургамлын сайхан нь*”(1934), “*Анчны дуу*”(1942), “*Ертөнцийн чимэг*” (1960) зэрэг шүлгүүдээрээ монголын яруу найрагт өөрийн шинэчлэлийг хийсэн монголын шинэ үеийн яруу найргийн уран сайхны хэл үүсэн бүрэлдэж бий болоход монгол ардын аман зохиол, монголын эртний бичгийн зохиолын уламжлалыг бүтээлчээр шинэчлэн хөгжүүлсэн зохиолч, яруу найрагч байжээ. Хэдийгээр түүний яруу найргийг өнөөгийн өндөрлөгөөс харахад аман яруу найргийн шинжтэй боловч энэ нь түүний бүтээлүүдийн үнэ цэнийг бууруулах учиргүй ба тэрээр монголын шинэ цагийн бичгийн яруу найраг бий болж хөгжих эх үндсийг тавихад жинтэй хувь нэмэр оруулсан болохыг үгүйсгэх аргагүй юм.

НОМ ЗҮЙ

Монгол хэлээр:

1. Аюурзана.Г. (2004) *Утга зохиолын тухай яриа*. Улаанбаатар.,
2. Гаадамба.Ш. (1988) Сампилдэндэв.Х. *Монгол ардын аман зохиол*. Улаанбаатар.,
3. Галбаатар.Д. (2002) *Уран зохиолын онолын ойлголт, нэр томъёоны тайлбар толь*. Токио.,
4. Галбаатар.Д. (2009) *Монголын уран зохиолын онол түүхийн зангилаа асуудлууд*. Улаанбаатар.,
5. Галбаатар.Д. Галбаяр.Г. (2009) *Уран зохиол шинжлэлийн удиртгал, ерөнхий онол*. Улаанбаатар.,
6. Дамдинсүрэн.Ц. (1998) *Бүрэн зохиол*. Улаанбаатар.,
7. Лувсанвандан.С.нар (1985) *Монголын орчин үеийн уран зохиолын түүх*. Улаанбаатар.,
8. *Монгол ардын дуу*. Ү (5). (1982) Улаанбаатар.,
9. Оюунбадрах.Д. (1998) *Монголын хүүхдийн уран зохиолын уламжлал*. Улаанбаатар.,
10. Пүрэв-Очир.Б. (2008) *Сайн үйлсийг бүтээж салаа замаар явсан эрдэмтэн зохиолч*. Улаанбаатар.,
11. Сампилдэндэв.Х. Яцковская.К.Н. (1984) *Монгол ардын уртын дуу*. Улаанбаатар.,
12. Сампилдэндэв.Х. (1987) *Монгол ардын зан үйлийн аман зохиол*. Улаанбаатар.,
13. Хасбаатар.Ц. (1973) *Утга зохиолын тухай бодол*. Улаанбаатар.,
14. Цэдэв.Д. (1998) *Ц.Дамдинсүрэн "Бүрэн зохиол" 1-р дэвтэр*. Улаанбаатар.,
15. Энхбаяр.С. (2008) *Утга зохиолын онол*. Улаанбаатар.,

Орос хэлээр:

1. Владимирцов.Б.Я. (1926). *Образцы монгольской народной Словесности*. (С.З. Монголия) Ленинград.,
2. Герасимович.Л.К. (1965) *Литература Монгольской Народной Республики (1921-1964)* изд. Ленинградского Университета.,

РЕЗЮМЕ

Писатель Цендийн Дамдинсүрэн написал многочисленные поэтические произведения, которые имеют характер народного фольклора.

Поскольку фольклор включает в себя народные песни, пословицы, крылатые выражения и небылицы, то произведения Дамдинсүрена также насыщены их элементами и выражениями. В его произведениях также использованы много оригинальных цитат из фольклора.

Несмотря на то, что его поэтические произведения имеют народный характер, они сумели оказать огромное влияние на развитие новой монгольской письменной поэзии.